



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ОНЦГОЙ КОМИССЫН АЛБАН
ДААЛГАВАР

2023 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 02

Сүхбаатар сум

Г “Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, Г
бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллах тухай”

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур орчин шинжилгээний газраас ирүүлсэн мэдээллээр Орхон, Сэлэнгэ, Ерөө, Хараа голд хэмжилт хийж үзэхэд үерийн түвшинд хүрсэн мөн 2023 оны дулааны улирлын мэдээгээр баруун болон төвийн аймгуудын нутгаар олон жилийн дунджаас ахиу хур тунадас орох төлөвтэй, мөн дулааны улиралд богино хугацаанд, бага хэмжээний газар нутгийг хамран ажиглагддаг дуу цахилгаантай, ус ихтэй, ширүүн аадар бороо орох магадлал өндөр байна.

Одоогийн байдлаар үерийн усанд 1 сумын 10 айл өрх өртөөд байна. Иймд болзошгүй үер, усны аюул ослоос урьдчилан сэргийлэх, аюулт, үзэгдэл, осол тохиолдсон үед шуурхай хариу арга хэмжээ авах зорилгоор **аймгийн онцгой комиссын гишүүд болон сумдын онцгой комиссын дарга нарт ДААЛГАХ нь:**

1. Аймгийн Ус, цаг уур, орчин шинжилгээний газраас шаардлагатай мэдээ мэдээллийг цаг алдалгүй солилцож хамтран ажиллах,

2. Гол, мөрөн нуурын арал, тохой, эрэг дагууд болон уулын ам, бэл, гуу жалга, судгийн аманд айл өрх суурьшихгүй байхыг анхааруулах, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа явуулахыг хориглох, эрсдэл бүхий газар нутагласан айл өрхийг нүүлгэн шилжүүлэх,

3. Үерийн хамгаалалтын далан, зам, талбайн ус зайлуулах зориулалттай инженерийн байгууламжид үзлэг, шалгалт зохион байгуулах, далан, суваг, шуудууны цэвэрлэгээг хийх,

4. Тээврийн хэрэгслийн жолооч, малчид, иргэдэд гүүр, гарамгүй газраар гол, мөрөн гатлахгүй байх, анхаарал болгоомжтой зорчих талаар анхааруулга, сэрэмжлүүлэг тогтмол хүргэх,

5. Үерийн аюул, усны осол тохиолдож болзошгүй газруудад урьдчилан сэргийлэх анхааруулга, сэрэмжлүүлэг, усны гүнийг заасан тэмдэг тэмдэглэгээ, самбар байрлуулах, шинэчлэх, хүн олноор цуглардаг болон эрсдэл бүхий

газруудад гэрэлтүүлэг, хяналтын камер суурилуулах, аврах цагираг, хөвөгч, татлага, олс зэргийг байрлуулах,

6. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг дайчлан гол мөрөн, нуурийн аюултай хэсэгт хаалт, хашлага хийх, тор татах,

7. Иргэдийн амралт, зугаалгын улирал эхэлж байгаа тул иргэдэд бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх, архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ голын усанд орохгүй байх талаар анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээлэл тогтмол хүргэх,


8. Сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэний түрэгч, чирэгч трактор, экскаватор, туулах чадвар сайтай машин механизмын судалгааг гаргаж шаардлагатай тохиолдолд дайчлан гаргах хуваарь гаргах,

9. Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 88/152 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам"-д заасны дагуу усны ослоос урьдчилан сэргийлэх ажилд тодорхой хөрөнгө хуваарилах,

Болзошгүй аюулт үзэгдэл, гамшгийн үед үүрэг гүйцэтгэх мэргэжлийн анги, гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн техник хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулан Онцгой байдлын газрын шуурхай удирдлагын төвийн 7036101, 70362255 холбогдож шаардлагатай мэдээ, мэдээлэл солилцон ажиллаж, албан даалгаврын биелэлтийг 2023 оны 7 дугаар сарын 18-ний өдрийн дотор aok@selenge.gov.mn цахим хаягаар ирүүлэхийг **аймгийн онцгой комиссын гишүүд болон сумдын онцгой комиссын дарга нарт** даалгасугай.

Албан даалгаврын биелэлтийг нэгтгэн аймгийн онцгой комисст танилцуулах, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн онцгой комиссын орлогч дарга, онцгой байдлын газар хурандаа /Г.Галбадрах/-д үүрэг болгосугай.

ДАРГА,


Н.ЛХАГВАДОРЖ

